



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 17 өдөр

Дугаар А/56

Улаанбаатар хот

Тариф шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5 дахь заалт, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 6.3 дахь хэсэг, Сангийн сайдын 2022 оны 279 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний нутгийн захиргааны агентлаг, нийслэл дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, Засаг дарга нарын албан хэрэгцээнд үйлчилдэг дуудлагын автомашины үйлчилгээнд мөрдөх үнийн тарифыг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2.Шинэчилсэн үнийн тарифыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдүүлэхийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар (Л.Хосбаяр)-т даалгасугай.

3.Дуудлагын автомашины үйлчилгээнд шаардагдах зардлыг жил бүрийн төсөвт тусгаж байхыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Б.Энхжин)-т, хэрэглэгч байгууллагатай дуудлагын автомашины үйлчилгээ үзүүлэх гэрээг шинэчлэн байгуулахыг Нийслэлийн Төр захиргааны авто бааз УТҮГ (Э.Болор-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

4.Энэ захирамж гарсантай холбогдуулан Нийслэлийн Засаг даргын 2008 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн “Тариф шинэчлэн батлах тухай” 409 дүгээр захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА  
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН  
ЗАХИРАГЧ



Х.НЯМБААТАР





Нийслэлийн Засаг даргын 2024 оны  
0.1 дүмт... сарын ... өдрийн  
А/5... захирамжийн хавсралт

ДУУДЛАГЫН АВТОМАШИНЫ ҮЙЛЧИЛГЭЭНД МӨРДӨХ ҮНИЙН ТАРИФ

д/д	Автомашины төрөл			1км-т тооцох тариф	Хүлээлгийн 1 цагт тооцох төлбөр
1	Сонота, аксент			1095	
2	Тоёото камри, сонота-7			1170	
3	Киа оптима, Ниссан тена, Сонота-8			1600	
4	Бага оврын автобус			1680	
5	Хөдөө ажлын автомашин	бензин хөдөлгүүртэй		1650	
		дизель хөдөлгүүртэй		2200	
6	Ачааны автомашин			1570	5,000
7	Автобус (дунд оврын)			2500	5,000
8	Автобус (том оврын)			3750	5,000